



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянтэс сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/174/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай хот 2024 он</p>	<p>Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-undraaD@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Х.Болдбаатар Утас: 99105506 Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Баасанжаргал Утас: 99032514 Цахим хаяг: BaasanjargalG@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	12
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	12
3.5.3 Нэмэлт төсөв	13
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	13
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	15
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Албан шаардлага	16
5.3 Зөвлөмж.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	0

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

БАЯНТЭС СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Э.БАТЗОРИГ-Д

2024.02.19 № 55
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянтэс сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянтэс сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Баянтэс сумын Засаг даргын Тамгын газарт Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас үнэ төлбөргүй шилжиж ирсэн 123,300,000 төгрөгийн автомашиныг тээврийн хэрэгсэл, 22,834,200 төгрөгөөр худалдан авсан өвс тэжээлийг бусад хангамжийн материал дансанд бүртгүүлж, залруулсан байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас тус сумын хэмжээнд өвөлжилт, хаваржилт хүндэрч малчдад тусламж дэмжлэг үзүүлэх зорилгоор даллуу татах болон өвс, тэжээл хүргэх шатахуун худалдан авах зориулалтаар 30,409,800 төгрөг, Бужир, Жавхлан багуудын нутаг дэвсгэрт гарсан ой хээрийн түймэрийг унтраахад 8,000,000 төгрөгийн шатахууны зардлын санхүүжилт олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Баянтэс сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар малчдад хөнгөлөлттэй үнээр өвс, тэжээл борлуулсны орлогыг хувь хүний дансанд төвлөрүүлсэн бэлэн мөнгө болон зарцуулалтын тайланд тооцоо хийж хяналт тавиагүй,

жолоочийн замын хуудасны бичилт дутуу, нягтлан бодогчтой тооцоо нийлдэггүй, шатахуун зарцуулалтын тайлангүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, мөн сэлбэг хэрэгсэл, модны суулгацыг данс бүртгэлд тусгаагүй шууд зардлаар тайлагнасан зэрэг нийт 5,675,200 төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, төсвөөс сумын аварга малчдын хүлээн авалт, нутгийн зөвлөлийн уулзалт, золгуут, шинэ жилийн арга хэмжээнд хүнсний материал, гарын бэлэг, шатахуун зэрэгт 8,234,000 төгрөгийн зардал гарган, зориулалт бус, үр ашиггүй зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлж, нутгийн зөвлөлийн уулзалтад архи, чихэр, жимс худалдан авч төсвөөс зориулалт бус, үрэлгэн зарцуулсан 420,000 төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож тус тус шийдвэрлэсэн.

Бусад асуудлын хэсэг

Баянтэс сумын Засаг даргын Тамгын газар нь сумын Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн 14,800,000 төгрөгийн автомашины граж, 89,895,700 төгрөгийн сумын төвийн гэрэлтүүлэг, 20,000,000 төгрөгийн тариалангийн талбайн хашаа зэргийг данс бүртгэлд тусгасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,554,121.00	12,148,721.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6,554,121.00	12,148,721.00
35400	Хангамжийн материал	6,554,121.00	12,148,721.00
35410	Бичиг хэргийн материал	148,840.00	248,840.00
35420	Аж ахуйн материал	6,405,281.00	8,240,281.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0	3,659,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	865,472,528.71	1,203,001,990.92
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	865,472,528.71	1,203,001,990.92
39200	Биет хөрөнгө	833,284,528.71	1,166,643,990.92
39201	Барилга, байгууламж, орон сууц	595,450,924.85	610,250,924.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	-137,209,086.97	-171,180,488.41
39203	Авто-тээврийн хэрэгсэл	333,284,800.00	456,584,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-77,894,473.41	-113,905,697.12
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	83,503,197.00	206,937,275.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-24,775,995.34	-38,457,749.24
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	103,407,086.00	99,942,086.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-75,403,066.11	-76,026,374.49
39214	Бусад үндсэн хөрөнгө	120,762,788.00	286,052,488.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-88,269,545.31	-93,981,174.57
39217	Ном	427,900.00	427,900.00
39300	Биет бус хөрөнгө	32,188,000.00	36,358,000.00
39301	Програм хангамж	3,022,000.00	7,522,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,032,000.00	-2,362,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	31,198,000.00	31,198,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	872,026,649.71	1,215,150,711.92
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,730,840.00	166,900.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,730,840.00	166,900.00
41300	Өглөг	4,730,840.00	166,900.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	4,730,840.00	166,900.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	867,295,809.71	1,214,983,811.92
51	Засгийн газрын хувь оролцоо	867,295,809.71	1,214,983,811.92
51100	Засгийн газрын оруулсан капитал	394,749,005.52	394,749,005.52
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	394,749,005.52	394,749,005.52
51200	Хуримтлагдсан үр дүн	445,600,497.38	793,288,499.59
51210	Өмнөх үеийн үр дүн	224,394,089.54	445,600,497.38
51220	Тайлант үеийн үр дүн	221,206,407.84	347,688,002.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	26,946,306.81	26,946,306.81
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	872,026,649.71	1,215,150,711.92

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	645,880,900.00	511,033,644.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	289,567,000.00	404,138,778.90

120	Нийтлэг татварын бус орлого	289,567,000.00	404,138,778.90
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	289,567,000.00	398,903,778.90
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	5,235,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	356,313,900.00	106,894,865.40
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,415,000.00	106,894,865.40
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,415,000.00	0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	106,894,865.40
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	340,898,900.00	0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	340,898,900.00	0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	424,674,492.16	622,130,549.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	424,674,492.16	622,130,549.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	398,837,792.94	621,956,928.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	221,119,133.78	345,592,656.59
210101	Үндсэн цалин	194,333,918.78	257,595,190.59
210102	Нэмэгдэл	25,887,278.00	83,426,966.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	0
210104	Урамшуулал	897,937.00	4,570,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	0	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,691,567.00	43,427,553.10
210201	Тэтгэврийн даатгал	18,710,457.08	29,777,390.67
210202	Тэтгэмжийн даатгал	2,201,228.17	3,452,428.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,760,982.48	2,761,942.71
210204	Ажилгүйдлийн даатгал	365,354.30	675,980.02
210205	Эрүүл мэндийн даатгал	3,653,544.97	6,759,811.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,846,940.00	25,158,900.00
210301	Гэрэл, цахилгаан	2,797,140.00	5,644,300.00
210302	Түлш, халаалт	24,049,800.00	19,514,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,275,315.00	33,765,460.00
210401	Бичиг хэрэг	2,159,200.00	3,796,300.00
210402	Тээвэр, шатахуун	20,387,740.00	25,808,060.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,917,600.00	3,961,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0	200,000.00
210408	Бараа материал акталсны зардал	2,810,775.00	0
2105	Нормативт зардал	0	450,000.00
210502	Хоол, хүнс	0	450,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,201,400.00	837,800.00

210604	Урсгал засвар	13,201,400.00	837,800.00
2107	Томилолт, зочны зардал	4,636,000.00	5,292,100.00
210701	Гадаад албан томилолт	0	0
210702	Дотоод албан томилолт	4,636,000.00	5,292,100.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,420,100.00	1,611,476.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,092,000.00	720,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232,100.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	469,091.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.00	227,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73,800.00	56,285.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	187,000.00	0
210807	Газрын төлбөр	138,400.00	138,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,647,337.16	165,820,982.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,583,000.00	71,961,823.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	513,400.00	150,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	62,550,937.16	93,709,159.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,836,699.22	173,620.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,835,800.00	0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,835,800.00	0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	899.22	173,620.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	893.5	0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5.72	173,620.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	221,206,407.84	-111,096,904.70
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	85,156.78
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	85,156.78
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	221,206,407.84	-111,182,061.48

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	356,313,900.00	106,894,865.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	356,313,900.00	106,894,865.40
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,415,000.00	106,894,865.40

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,415,000.00	0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	106,894,865.40
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	340,898,900.00	0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	340,898,900.00	0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	356,313,900.00	565,764,929.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	356,313,900.00	565,764,929.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	330,477,200.78	565,591,308.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	214,653,406.50	345,460,909.69
210101	Үндсэн цалин	187,868,191.50	241,600,851.52
210102	Нэмэгдэл	25,887,278.00	99,584,878.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	0
210104	Урамшуулал	897,937.00	4,275,180.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,157,294.28	43,559,300.00
210201	Тэтгэврийн даатгал	24,648,894.28	29,620,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,162,100.00	3,484,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,667,500.00	2,787,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	448,300.00	696,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,230,500.00	6,969,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,006,900.00	25,158,900.00
210301	Гэрэл, цахилгаан	3,547,100.00	5,644,300.00
210302	Түлш, халаалт	24,459,800.00	19,514,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,315,700.00	37,362,063.00
210401	Бичиг хэрэг	1,741,200.00	3,416,900.00
210402	Тээвэр, шатахуун	15,656,900.00	30,137,463.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,917,600.00	3,807,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,401,400.00	1,350,000.00
210604	Урсгал засвар	14,401,400.00	1,350,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,636,000.00	5,292,100.00
210702	Дотоод албан томилолт	4,636,000.00	5,292,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,420,100.00	9,605,476.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,092,000.00	8,714,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232,100.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	469,091.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.00	227,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73,800.00	56,285.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	187,000.00	0

210807	Газрын төлбөр	138,400.00	138,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,886,400.00	97,802,560.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,583,000.00	97,499,160.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.00	303,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,836,699.22	173,620.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,835,800.00	0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,835,800.00	0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	899.22	173,620.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	893.5	0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5.72	173,620.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0	-458,870,063.69
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	-458,870,063.69

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	394,749,005.52	26,946,306.81	224,394,089.54	646,089,401.87
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	394,749,005.52	26,946,306.81	445,600,497.38	867,295,809.71
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	394,749,005.52	26,946,306.81	224,394,089.54	646,089,401.87
9	Тайлант үеийн үр дүн	0	0	221,206,407.84	221,206,407.84
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	394,749,005.52	26,946,306.81	445,600,497.38	867,295,809.71
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	394,749,005.52	26,946,306.81	793,288,499.59	1,214,983,811.92
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	394,749,005.52	26,946,306.81	445,600,497.38	867,295,809.71
19	Тайлант үеийн үр дүн	0	0	347,688,002.21	347,688,002.21

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	474,927,800.00	458,870,063.69

21	УРСГАЛ ЗАРДАЛ	474,927,800.00	458,870,063.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	474,927,800.00	458,870,063.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	348,474,300.00	345,460,909.69
210101	Үндсэн цалин	248,764,000.00	241,600,851.52
210102	Нэмэгдэл	99,710,300.00	99,584,878.17
210104	Урамшуулал	0	4,275,180.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,559,300.00	43,559,300.00
210201	Тэтгэврийн даатгал	29,620,300.00	29,620,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,484,800.00	3,484,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,787,800.00	2,787,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	696,900.00	696,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,969,500.00	6,969,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,354,400.00	25,158,900.00
210301	Гэрэл, цахилгаан	5,644,300.00	5,644,300.00
210302	Түлш, халаалт	19,710,100.00	19,514,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,298,200.00	22,735,978.00
210401	Бичиг хэрэг	3,870,300.00	3,416,900.00
210402	Тээвэр, шатахуун	15,510,300.00	15,511,378.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,917,600.00	3,807,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,350,000.00	1,350,000.00
210604	Урсгал засвар	1,350,000.00	1,350,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,572,100.00	4,572,100.00
210702	Дотоод албан томилолт	4,572,100.00	4,572,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,328,100.00	1,611,476.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,200,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	469,091.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.00	227,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73,800.00	56,285.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400.00	0
210807	Газрын төлбөр	138,400.00	138,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15,700.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,991,400.00	14,421,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,688,000.00	14,118,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.00	303,400.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	474,927,800.00	458,870,063.69
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0
310001	Улсын төсвөөс санхүүжих	0	0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	467,119,800.00	458,870,063.69
320001	Орон нутгийн төсвөөс	467,119,800.00	458,870,063.69
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,808,000.00	0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	7,808,000.00	0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	19	19
620001	Удирдах ажилтан	7	7
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	3	3
620004	Гэрээт ажилтан	0	0

65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	19	19
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8	8
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	0	0
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	0	0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

			<i>/ төгрөгөөр /</i>
Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн	
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	106,894,865.40	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	106,894,865.40	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	106,721,245.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	14,626,085.00	
210402	Тээвэр, шатахуун	14,626,085.00	
2107	Томилолт, зочны зардал	720,000.00	
210702	Дотоод албан томилолт	720,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,994,000.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,994,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,381,160.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	83,381,160.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	173,620.40	
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	173,620.40	
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	173,620.40	
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	106,894,865.40	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	106,894,865.40	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	106,894,865.40	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянтэс сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монгол улсын Засгийн газар, аймгийн Засаг дарга, сумын Засаг даргын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрүүд, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түүний Тэргүүлэгчдийн хуралдаанаас гаргасан шийдвэрийг Засаг

даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах төрийн байгууллага, мэргэжилтэн, албан хаагч багийн Засаг дарга нарын ажлыг уялдуулан оновчтой бодлого, зохицуулалтаар хангаж орон нутгийн хөгжлийн төлөө төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага иргэдэд төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэж, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр иргэддээ үнэнч шударга үйлчлэхэд чиглэгдэнэ.

Тус байгууллага нь “Төрийн үйлчилгээний ил тод шударга шуурхай байдлыг хангаж ажиллахад төрийн байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлж, иргэдэд түргэн шуурхай хүргэх, сахилга хариуцлага дэг журмыг дээшлүүлэн аюулгүй амьдрах орчинг бүрдүүлнэ” гэсэн зорилгын хүрээнд 2023 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилт, 92 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийг эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн биелэлт 92.9 хувьтай үнэлэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Баянтэс сумын Засаг даргын Тамгын газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн албаны тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Шилэн дансны тухай, Хөдөлмөрийн тухай, Татварын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн хэмнэлтийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөхөөс гадна Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам бусад хууль, тогтоомж, журмуудыг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит болон аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянтэс сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянтэс сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 343,124.1 мянган төгрөгөөр буюу 28.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	6,554.1	12,148.7	5,594.6
Үндсэн хөрөнгө	865,472.5	1,203,002.0	337,529.5
Нийт хөрөнгө	872,026.6	1,215,150.7	343,124.1
Өр төлбөр	4,730.8	166.9	(4,563.9)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	867,295.8	1,214,983.8	347,688.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	872,026.6	1,215,150.7	343,124.1

Дээрх хүснэгтээс харахад бараа материал, үндсэн хөрөнгө дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

Бараа материалын эхний үлдэгдэл 6,554.1 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 82,890.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 5,235.0 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 82,530.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 12,148.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,594.6 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 32,420.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 275,603.8 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, шийдвэрийн дагуу 3,465.0 мянган төгрөгийн хөрөнгө акталж, жилийн эцэст 1,698,915.5 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 93,709.1 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 347,688.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой болно.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр, нийт зарлагыг 392,343.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 7,808.0 мянган төгрөгөөр бууруулж, нийт 384,535.2 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 82,584.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэх засаглал хөтөлбөрийн үндсэн болон баг хороо, мэдээлэл сурталчилгаа, орон нутгийн нөөц хөрөнгө зэрэг 6 үйл

ажиллагааны зардлыг санхүүжүүлэхээр 467,119.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 466,187.8 мянган төгрөгийн санхүүжилт, олгож, гүйцэтгэл 458,870.0 мянган төгрөг буюу 98.4 хувьтай бөгөөд үйл ажиллагааны орлого 7,317.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Код	Хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	376,964.8	376,032.9	931.9	99.8
2	80106	Баг хорооны үйл ажиллагааны зардал	71,075.0	67,999.1	3,075.9	95.7
3	80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	1,200.0	720.0	480.0	0.0
4	81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.0	10,808.0	-5,808.0	216.2
5	81701	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	12,880.0	3,310.0	9,570.0	25.7
		Дүн	467,119.8	458,870.0	8,249.8	98.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр нийт 106,894.8 мянган төгрөгийн орлого орсон бөгөөд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 49,991.7 мянган төгрөг, аймгийн Засаг даргын Тамгын газраас 49,063.1 мянган төгрөг, аймгийн Статистикийн хэлтсээс 1,839.2 мянган төгрөг, өөрийн орлого 1,270.0 мянган төгрөг, 2022 оны үлдэгдэл 4,730.8 мянган төгрөг зэргээс бүрдсэн байна. Үүнийг Жавхлан, Бужир багт гарсан түймэр, мод тарьж цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил, өвөлжилт хүндэрсэнтэй холбоотой даллуу татах, өвс тэжээл хүргэх шатахуун, малын түүвэр судалгааны шатахуун, хамтарсан багийн зардал, сургалт, томилолт, огтоно устгал зэрэгт зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас 173.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ, төсөл хөтөлбөр гараагүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөг/

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Нээлттэй тендер шалгаруулалт	Мод тарьж цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил	50,000.0	49,991.7
		ДҮН	50,000.0	49,991.7

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянтэс сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэл, сангийн сайдын тушаал, журамтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баасанжаргал гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ц.Оюунсүвд аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянтэс сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 3/04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлтийг нийт хөрөнгө 872,026.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,080.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 9,810.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгө 1,215,150.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 18,227.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 13,670.4 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй ч батлагдсан төсвийн хүрээнд зарлага гарган ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор (shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим санд оруулсан байдлыг анхан шатны баримт, мөнгөн гүйлгээний журналтай тулган шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 80,394.8 мянган төгрөгийг мэдээлээгүй байна. Бусад мэдээллийг тухай бүр оруулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Баянтэс сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 131,244.7 мянган төгрөгийн зөрчилд 4 заалт зөвлөмж, 7,383.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлснийг тус тус 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	7,383.6	2	7,383.6	100
Зөвлөмж	4	123,861.1	4	123,861.1	100
Нийт дүн	6	131,244.7	6	131,244.7	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 188,120.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 188,120.0 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

Малын тэжээлийг бараа материалын тайланд орлого аваагүй, шууд зардлаар тайлагнасан 22,384.2 мянган төгрөг, тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй өглөгийг санхүүгийн тайланд тусгасан 10,015.8 мянган төгрөг, худалдан авсан үндсэн хөрөнгийг хандиваар бүртгэсэн 32,420.0 мянган төгрөг, хандиваар ирсэн автомашиныг данс бүртгэлд тусгаагүй 123,300.0 мянган төгрөгийг бүртгэсэн зэрэг алдаа гаргасан байна. Энэ нь УСНББОУС-1, АДБОУС 200, 2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4, 7.1.3.5 дахь заалтууд, Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д “Тусламж, хандивын

орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 15 дугаар зүйлийн 15.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна", 15.2-д "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасан, Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-тай нийцэхгүй, үнэн зөв байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 14,329.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 8,234.0 мянган төгрөгийн төлбөрийн зөрчилд албан шаардлага, 5,675.2 мянган төгрөгийн зөвлөмж, 420.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

5.1 Төлбөрийн акт

Засаг даргын нөөц хөрөнгөөс нутгийн зөвлөлийн золголтын арга хэмжээнд 420.0 мянган төгрөгөөр архи, чихэр, жимс худалдан авч төсвийг зориулалт бус, үрэлгэн зарцуулсан байна.

5.2 Албан шаардлага

Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын аварга малчдын хүлээн авалт, нутгийн зөвлөлийн уулзалт, золголт, шинэ жилийн арга хэмжээнд 8,234.0 мянган төгрөгөөр хүнсний материал, гарын бэлэг, шатахуун худалдан авч, үр ашиггүй, зориулалт бус зарцуулсан байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Малчдад хөнгөлөлттэй олгосон өвс, тэжээл борлуулсны орлогыг хувь хүний дансанд төвлөрүүлж, бэлэн мөнгөний тайлан гаргаагүй, зарцуулалтын тайлан тооцоо хийж хяналт тавьдаггүй, аудитын явцад нотлох баримтыг ирүүлээгүй зөрчил илэрсэн нь УСНББОУС-1, АДБОУС 200, 2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4, 7.1.3.5 дахь заалт, мөн Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын аюулгүй нөөцийн өвс тэжээлийг худалдан борлуулсны орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд буцаан төвлөрүүлэх, хяналтыг хэрэгжүүлэх, зориулалтын дагуу зарцуулж, тайлагнах, анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллах;

2. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сэлбэг хэрэгсэл, модны суулгац худалдан авсан анхан шатны баримтгүй, уг бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй шууд зардлаар тайлагнасан 3,540.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь УСНББОУС-1, АДБОУС 200, 2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4, 7.1.3.5 дахь заалт, мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.5-д "бүх орлого", 14.4.6-д "бүх зардал", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авсан бараа материалыг тухай бүр данс бүртгэлд тусган, анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллах;

3. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Жолоочийн замын хуудасны бичилт дутуу, нягтлан бодогчтой тооцоо нийлдээгүй, шатахуун зарцуулалтын тайлангүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй 2,135.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь УСНББОУС-1, АДБОУС 200, 2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4, 7.1.3.5 дахь заалт, мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шатахууны зарцуулалт, хэтрэлт, хэмнэлтийн тооцоог хийж, нормоор тооцож олгож, зарцуулалтын тайлан гаргаж анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллах;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 31-ний дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Заглуулсан		Заглуулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Малын тэжээлийг бараа материалын тайланд орлого аваагүй, шууд зардлаар тайлагнасан	1	22,384.20			1	22,384.20	1	22,384.20	0	0		
Тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй өглөгийг санхүүгийн тайланд тусгасан	1	10,015.80			1	10,015.80	1	10,015.80				
Худалдан авсан үндсэн хөрөнгийг хандиваар бүртгэсэн	1	32,420.00			1	32,420.00	1	32,420.00				
Хандиваар ирсэн автомашиныг данс бүртгэлд тусгаагүй	1	123,300.00		123,300.00				123,300.00				
Дүн	4	188,120.00	0	123,300.00	3	64,820.00	3	188,120.00	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шийгжүүлсэн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Малчдад хөнгөлөлттэй олгосон өвс, тэжээл борлуулсны орлогыг хувь хүний дансанд төвлөрүүлж, бэлэн мөнгөний тайлан гаргаагүй, зарцуулалтын тайлан тооцоо хийж хяналт тавьдаггүй, аудитын явцад нотлох баримтыг ирүүлээгүй	1	-					1	-				
Сэлбэг хэрэгсэл, модны суулгац худалдан авсан анхан шатны баримтгүй, уг бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй шууд зардлаар тайлагнасан	1	3,540.00					1	3,540.00				
Жолоочийн замын хуудасны бичилт дутуу, нягтлан бодогчтой тооцоо нийлдэггүй, шатахуун зарцуулалтын тайлангүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй	1	2,135.20					1	2,135.20				
Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын аварга малчдын хүлээн авалт, нутгийн зөвлөлийн уулзалт, золголт, шинэ жилийн арга хэмжээнд 8,234.0 мянган төгрөгөөр хүнсний материал, гарын бэлэг, шатахуун худалдан авч, үр ашиггүй, зориулалт бус зарцуулсан	1	8,234.00			1	8,234.00	0	-				
Засаг даргын нөөц хөрөнгөөс нутгийн зөвлөлийн золголын арга хэмжээнд 420.0 мянган төгрөгөөр архи, чихэр, жимс худалдан авч төсвийг зориулалт бус, үрэлгэн зарцуулсан	1	420.00	1	420.00			0	-				
Дүн	5	14,329.20	1	420.00	1.00	8,234.00	3	5,675.20	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал


/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:


ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2024.02.22

АУДИТЫН МЕНЕЖЕР



Х.БОЛДБААТАР

2024.02.22

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



Г.БААСАНЖАРГАЛ

2024.02.22